

## JENESYS 2017 Монголын залуучуудын Япон дахь сургалт хөтөлбөрийн тайлан

(Оролцогч орон: Монгол улс/ Сэдэв: 1-р групп “Япон соёл”

2-р групп “Шинжлэх ухаан, технологи”

3-р групп “Спорт”)

### 1. Хөтөлбөрийн агуулга

Япон орныг гадаадын хүүхэд залуучуудад танилцуулах зорилгоор “JENESYS 2017” хөтөлбөрийн хүрээнд Монгол улсаас ахлах сургуулийн сурагчид, оюутнуудаас бүрдсэн нийт 83 хүүхэд залуус 2018 оны 3 сарын 11 өдрөөс 3 сарын 18 өдрүүдэд 7 хоног 8 өдрийн туршид Япон оронтой танилцан аялж, япон айлд байрлах гэх мэт хөтөлбөрүүдээр дамжуулан япон хүмүүстэй танилцахаас гадна, японы улс төр, нийгэм, түүх, дэвшилтэт болон уламжлалт үйлдвэрлэл, соёлтой танилцаж жуулчдын олноор үзэж сонирхдог газруудыг үзэж, японы талаар олон талын ойлголттой болж, япон монгол хоёр орны хүүхэд залуучуудын нөхөрсөг харилцааг бататгалаа.

Хөтөлбөрт хамрагдагсад эхлээд Япон соёлтой танилцах лекц сонсож, дараа нь 3 группт хуваагдаж, тус тус хөтөлбөрийн арга хэмжээнд оролцож, япон болон япон соёлын талаарх ойлголтоо гүнзгийрүүлэв. “Япон соёл”-н 1-р группийнхэн София их сургуулиар айлчлахаас эхлээд, ус дахин боловсруулах төв болон газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босголтын ажил явагдаж байгаа Күмамото цайзыг үзэж танилцах зэргээр байгаль орчин, байгалийн гамшгаас хамгаалах талаарх мэдлэг, түүнчлэн анимэ ба уламжлалт жүжиг гэх мэт япон соёлтой холбогдох бүхий л мэдлэгтэй болсон билээ. “Шинжлэх ухаан, технологи”-н 2-р группийнхэн робот, сансарын хөгжлийн технологи гэх мэт хамгийн сүүлийн үеийн технологитай танилцаж, технологи шинжлэх ухааны их сургуулиар айлчлан, орчин үеийн үйлдвэрлэлийг үзэж танилцсан юм. 3-р группийнхэн “Спорт”-н чиглэлээр Монгол бөх ба япон сумогийн ялгааны тухай лекц сонсож, жудо барилдах гэх мэт спортоор дамжуулан япон улсыг танин мэдсэн билээ.

#### 【Оролцогч улс, оролцогчдын тоо】

Монгол улс Нийт 83 хүүхэд, залуучууд

1-р групп Япон хэл, япон соёл сонирхогчид (Сэдэв: Япон соёл) 39 хүн

2-р групп Шинжлэх ухааны чиглэлээр сурдаг ахлах сургуулийн сурагчид (Сэдэв: Шинжлэх ухаан, технологи) 22 хүн

3-р групп Спорттой холбоотой залуучууд (Сэдэв: Спорт) 22 хүн

#### 【Айлчилсан газар】

1-р групп Токио, Күмамото

2-р групп Токио, Нийгата

3-р групп Токио, Хирошима

### 2. Өдрийн хуваарь

#### 1-р групп

3 сарын 11 өдөр	(Ня)	Японд ирэх Чиг баримжаа олгох танилцуулга
3 сарын 12 өдөр	(Да)	Лекц: Япон соёлын тухай София их сургуулиар айлчлах

		Токио хотын захиргааг үзэж танилцах
3 сарын 13 өдөр	(Мя)	Нарита уулын Фүкагава хийдийг үзэж танилцах Сүгинами Анимэйшон музей Очиай ус дахин боловсруулах төв
3 сарын 14 өдөр	(Лха)	Күмамото руу явах Хонда Моторс ХХК Күмамото дахь үйлдвэрийг үзэж танилцах
3 сарын 15 өдөр	(Пү)	Япон соёлтой танилцах: Хачиёза Homestay
3 сарын 16 өдөр	(Ба)	Газар хөдөлсөн газраар явж үзэх: Күмамото цайз
3 сарын 17 өдөр	(Бя)	Токио руу явах Тайлан илтгэл
3 сарын 18 өдөр	(Ня)	Шинжлэх ухаан, технологийн шинэчлэлийн Үндэсний музей Эх орондоо харих
<b>2-р групп</b>		
3 сарын 11 өдөр	(Ня)	Японд ирэх Чиг баримжаа олгох танилцуулга
3 сарын 12 өдөр	(Да)	Лекц: Япон соёлын тухай Чиба Технологийн их сургуулиар айлчлах Токио Скай цүриг үзэж танилцах
3 сарын 13 өдөр	(Мя)	Сайбадайн студи Сансар, агаарын судалгаа, хөгжлийн байгууллага “Цүкүба сансрын төв”-г үзэх
3 сарын 14 өдөр	(Лха)	Нийгата руу явах Цүбамэ хотын аж үйлдвэрийн музей үзэх Санжо Кажу Доожо үзэж танилцах Сувада үйлдвэрийг үзэж танилцах
3 сарын 15 өдөр	(Пү)	Нагаока технологийн их сургуулиар айлчлах Homestay
3 сарын 16 өдөр	(Ба)	Ардын түүхийн музей Цасны орон танхимыг үзэж танилцах
3 сарын 17 өдөр	(Бя)	Токио руу явах Тайлан илтгэл
3 сарын 18 өдөр	(Ня)	Асакүса, Накамисэг үзэж танилцах Эх орондоо харих
<b>3-р групп</b>		
3 сарын 11 өдөр	(Ня)	Японд ирэх Чиг баримжаа олгох танилцуулга
3 сарын 12 өдөр	(Да)	Лекц: Япон соёлын тухай Японы биеийн тамирын их сургуулиар айлчлах Токиогийн Олимпийн дурсгалд зориулсан галерейг үзэж танилцах
3 сарын 13 өдөр	(Мя)	Кодоканг үзэх, биечлэн оролцох Токио Олимпийн наадам 2020 цэнгэлдэх хүрээлэн баригдах газрыг үзэх Лекц: Япон сумогийн тухай
3 сарын 14 өдөр	(Лха)	Хирошима руу явах Үсэг, дүрс бичих Мияжима / Янукушима сүм үзэж танилцах
3 сарын 15 өдөр	(Пү)	Хирошимагийн энхтайвны дурсгалын музей/ Энх тайвны дурсгалын цэцэрлэгт хүрээлэнг үзэж танилцах Лекц: Атомын бөмбөгний гамшгаас амьд үлдсэн хүний яриа Homestay

3 сарын 16 өдөр	(Ба)	Сатакэ компанитай танилцах
3 сарын 17 өдөр	(Бя)	Токио руу явах Тайлан илтгэл
3 сарын 18 өдөр	(Ня)	Токио тава үзэх Эх орондоо харих

### 3. Хөтөлбөрийн явцад авсан зургууд

### Бүх группуудын оролцсон нэгдсэн хөтөлбөр



3 сарын 11 өдөр  
【Чиг баримжаа олгох танилцуулга】  
Бэрмонт зочид буудал



3 сарын 12 өдөр 【Лекц】  
Японы Соёлын Хилийн чанад дахь Дэмжих  
Холбоо



3 сарын 17 өдөр 【Тайлан илтгэл】  
ТКР Шинагава хурлын төв танхим

### 1-р групп





3 сарын 12 өдөр 【Айлчлах】  
София их сургууль



3 сарын 12 өдөр 【Үзэж танилцах】  
Токио хотын захиргаа



3 сарын 13 өдөр 【Үзэж танилцах】  
Нарита уулын Фүкагава хийд



3 сарын 13 өдөр 【Үзэж танилцах】  
Сүгинами Анимэйшон музей



3 сарын 13 өдөр 【Үзэж танилцах】  
Очий Ус дахин боловруулах төв



3 сарын 14 өдөр 【Компаниар айлчлах】  
Хонда Моторс ХХК Күмамото дахь үйлдвэр



3 сарын 15 өдөр 【Япон соёлтой танилцах】  
Хачиёза

3 сарын 15 өдөр 【Homestay】



3 сарын 16 өдөр  
【Газар хөдөлсөн газраар явж үзэх】  
Кумамото цайз



3 сарын 18 өдөр 【Үзэж танилцах】  
Шинжлэх ухаан, технологийн шинэчлэлийн  
Үндэсний музей

**2-р групп**



3 сарын 12 өдөр 【Үзэж танилцах】  
Чиба Технологийн их сургууль



3 сарын 12 өдөр 【Үзэж танилцах】  
Токио Скай цури



3 сарын 13 өдөр 【Үзэж танилцах】  
Сайбадайн студи



3 сарын 13 өдөр 【Үзэж танилцах】  
Сансар, агаарын судалгаа, хөгжлийн  
байгууллага “Цүкуба сансрын төв”





3 сарын 14 өдөр 【Үзэж танилцах】  
Цубамэ хотын аж үйлдвэрийн музей



3 сарын 14 өдөр 【Үзэж танилцах】  
Санжо Кажи Доожо



3 сарын 14 өдөр 【Үзэж танилцах】  
Сүвада үйлдвэр



3 сарын 15 өдөр 【Айлчлах】  
Нагаока технологийн их сургууль



3 сарын 15 өдөр 【Homestay】

**3-р групп**



3 сарын 12 өдөр **【Их сургуульд айлчлах】**  
Японы биеийн тамирын дээд сургууль



3 сарын 13 өдөр **【Үзэж танилцах, оролцох】**  
Кодокан



3 сарын 13 өдөр **【Лекц】**  
Японы Сумогийн тухай



3 сарын 14 өдөр **【Соёлтой танилцах】**  
Үсэг, дүрс бичих



3 сарын 14 өдөр **【Үзэж танилцах】**  
Мияжима / Янукушима сүм



3 сарын 15 өдөр **【Үзэж танилцах】**  
Хирошимагийн энхтайвны дурсгалын музей/  
Энх тайвны дурсгалын цэцэрлэгт хүрээлэн

	
<p>3 сарын 15 өдөр <b>【Лекц】</b> Атомын бөмбөгний гамшгаас амьд үлдсэн хүний яриа</p>	<p>3 сарын 15 өдөр <b>【Homestay】</b></p>
	
<p>3 сарын 16 өдөр <b>【Үзэж танилцах】</b> Сатакэ ХХК</p>	

#### 4. Оролцогчдын сэтгэгдэл

- Биднийг яг л өөрсдийн үр хүүхэд мэт халуун дотно хүлээн авсанд баярлалаа.
- Миний хувьд япон айлд байрласан нь хамгийн сэтгэлд хоногшсон хөтөлбөрийн нэг байлаа. Япон айлын гэр бүлийнхэн биднийг маш дотноор угтаж, халуун дулаан уур амьсгал дунд байлгасан.
- Бид бүхнийг тав тухтай байлгахын тулд хөтөлбөрийг эхлэхээс нь өмнө маш сайн бэлдэж сэтгэл гарган хандсанд талархлаа илэрхийлье.  
Түүнчлэн, бидний хувьд ч цаашид ирээдүйд минь ихээхэн хувь нэмэр өгөх олон зүйлсийг сургаж өгсөнд баярлаж байгаагийн зэрэгцээ маш сэтгэл хангалуун үдлээ.
- ◆Айлчлалын явцад тааралдсан япон хүн бүр эелдэг харьцаатай, аливаа зүйлд хариуцлагатай ханддаг юм шиг санагдсан. Хаана ч явсан гудамж талбай цэвэрхэн, бүгд дор бүрийнхээ ажлыг хийгээд зөв боловсон явдаг ухамсартай юм байна гэж бодогдсон.



## **5. Хүлээн авсан хүмүүсийн сэтгэгдэл**

**JENESYS2017 Монголын залуучуудын Япон дахь сургалт хөтөлбөрийн 3-р группийнхэнд япон айлд байрлах арга хэмжээнд оролцохоор алс холоос Кита хирошима тосгоныг зорин ирсэнд маш их баярлалаа. Монголын хүүхэд залуучуудийг баяр хөөрөөр дүүрэн дурсгамжаар үдэн гаргаж чадсандаа хүлээн авсан япон айлын гэр бүлийнхэн болон хамтран ажилласан хамт олон маань сэтгэл хангалуун байгаа. Япон айлын гэр бүлийнхэн эхэндээ хэл үгээ ололцохгүй болов уу хэмээн санаа зовж байсан хэдий ч, аль хэдийн бие биенээ харилцан хүндэтгэж халуун дотно харилцаа тогтоож чадсан гэж бодож байна. “2020 онд Монгол улсыг дэмжицгээе !” хэмээх уриаг гарган хүлээн авсан япон айлын хүмүүстэйгээ ярилцаж байлаа.**

**6. Оролцогсдын Японы талаарх мэдээллийг түгээсэн байдал**

**1-р групп**



Товч агуулга) Япон соёлтой танилцав: Ячидзагийн тухай



Товч агуулга) Шинжлэх ухаан, технологийн шинэчлэлийн Үндэсний музейн тухай

**2-р групп**



Товч агуулга) Токио Скай цүри-гийн тухай



Товч агуулга) Үзэж танилцав: Сансар, агаарын судалгаа, хөгжлийн

	байгууллага “Цүкүба сансрын төв”-н тухай
--	--

**3-р групп**

<p>Товч агуулга) Айлчлав:Кодокангийн тухай</p>	<p>Товч агуулга) Хирошимагаар айлчилсан байдал Хирошимагийн энхтайвны дурсгалын музей/ Энх тайвны дурсгалын цэцэрлэгт хүрээлэн</p>

**7. Тайлан илтгэлийн үеэр яригдсан Эх орондоо ирсний дараа хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө**

- Хөтөлбөрт оролцогчдын цуглаан хийж, дараагийн оролцогчдод зөвлөгөө өгнө. Япон соёлын тухай бусад ангийнхаа хүүхдүүдэд ярьж өгнө.
- Япон соёлыг улам дэлгэрүүлж, ангийнхандаа болон сургуулийнхаа бүх хүүхдүүдэд зааж өгнө.
- Ангидаа тайлан тавьж, сургуульдаа япон хэлний талаар таниулга хийж, өргөн хүрээнд сурталчлах ажлыг хиймээр байна.
- Энэ хөтөлбөрт оролцсон сэтгэгдлээрээ дуу хийж сонсгоё гэж бодож байна.
- Facebook болон Instagram -р дамжуулан японы түүх, уламжлалт соёлын тухай мэдээлэл тарааж, интернэтээр дэлгэрүүлнэ.
- Спортын хөгжлийн түүхэн хувьсалын тухай мэдээлэл тараана.